



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 8/174

Арвайхээр

Г Зөвлөл байгуулах тухай Г

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ-2020” хөтөлбөрийн 2.1.8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн банкны итгэлцлийн сан болох Японы Нийгмийн хөгжлийн сангийн санхүүжилээр Японы Хүүхдийг Ивээх сангийн хэрэгжүүлэх “Орон нутгийн ёсвэр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрпренершипийн боловсрол олгох” төслийг удирдан чиглүүлэх үүрэг бүхий “Төслийн аймгийн зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Аймгийн Засаг даргын хүн ам зүй, хөдөлмөр, хамгаалал, нийгмийн даатгал, боловсрол, соёл, урлаг, спорт, барилга, хот байгуулалт, дэд бүтэц, экологи, ногоон хөгжил, аялал жуулчлалын салбар хариуцсан орлогч

Нарийн бичгийн дарга: Японы Хүүхдийг ивээх сангийн ажилтан

Гишүүд: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн

-Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн газрын Хөдөлмөрийн хэлтсийн дарга

-Аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

-Аймгийн Засаг даргын дэргэдэх Насан туршийн боловсролын төвийн сургалтын менежер

-Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний албаны дарга

-Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын дотоод хяналт, хууль эрх зүй, өргөдөл, гомдол, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн

-Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Өвөрхангай аймаг дахь салбарын дарга

-Өвөрхангай аймаг дахь Технологийн коллежийн санхүү, эдийн засгийн багш

-“Дэлгэрэх бүтээмж” төрийн бус байгууллагын тэргүүн

2. Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, явц үр дунг жилийн эцэст аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд мэдээлж ажиллахыг “Төслийн аймгийн зөвлөл”-ийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД

011100373